


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2019



Өдөр бүр уулзах үндэсний
шилдэг компани

20

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

19

АГУУЛГА

НЭГ.

ХҮНИЙ НӨӨЦ, ГАДААД ХАРИЛЦААНЫ АЖЛЫН ХҮРЭЭНД

16

- 1.1. Хүний нөөц, хөдөлмөрийн харилцааны талаар
- 1.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар

ХОЁР.

ШУУДАНГИЙН ТЕХНОЛОГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

20

- 2.1. Улс хоорондын шуудангийн сүлжээний ашиглалтын тасралтгүй, найдвартай хэвийн үйл ажиллагааг хангах талаар
- 2.2. Улс хоорондын шуудангийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэх талаар
- 2.3. Дотоод шуудангийн үйл ажиллагааны талаар

ГУРАВ.

ТЭЭВЭР ЗУУЧ, ЛОГИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

26

- 3.1. Транзит шуудан - Автомашин, төмөр замаар транзит тээвэр
- 3.2. Хот доторх гараас гарт хүргэлтийн үйлчилгээ

ДӨРӨВ.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД 29

4.1. Программ хангамж хөгжүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг хангах

ТАВ.

МАРК, ҮНЭТ ЦААСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД 32

5.1 Марк үйлдвэрлэл

5.2. Дугтуй, үнэт цаасны үйлдвэрлэл

ЗУРГАА.

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ 36



Мөндчилгээ



**Эрхэм хүндэт харилцагчид, түнш байгууллагууд, хувьцаа эзэмшигчид
болон хамтран ажиллагсад аа!**

Манай компанийн хувьд 2019 он шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн, үр ашгийг нэмэгдүүлж ажилласнаар компанийн орлогын тогтмол өсөлтийг ханган, үйл ажиллагаандаа эерэг үр дүн, дэвшил авчирсан ололт амжилтын жил байлаа.

Бид улс хоорондын транзит шууданг өргөжүүлж, дотоодын логистик үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлж, шуудан ялган боловсруулах төвийг шинээр ашиглалтад оруулж, хүргэлтийн шинэ чиглэл, технологийг нэвтрүүлэн ажиллалаа.

Улс орныхоо өнцөг булан бүрт ажиллаж, амьдарч байгаа нийт иргэд, харилцагч, түншүүддээ шуудангийн үйлчилгээг хүргэж, дэлхийн олон улстай холбох их ажлыг амжуулахаар 1000 орчим шууданч шонхрууд эрдэм мэдлэг, ур чадвар, билиг оюунаа зориулан “Өдөр бүр уулзах үндэсний шилдэг компани” болохыг эрхэм болгон зүтгэж байна.

Бид цаашдаа ахмад үеийнхээ түүчээлэн авч ирсэн нэгэн зууны бахдам түүхийг үргэлжлүүлэн, орчин үеийн үйлчилгээ, технологийн боломжийг ажилдаа нэвтрүүлж, шинэ өнгө төрх, шилдэг боловсон хүчин, тохилог цэвэр орчин бүхий ухаалаг үйлчилгээг урьтал болгон, Монгол Улсынхаа хөгжилд хүч, түрлэг нэмсэн шуудангийн үйлчилгээний байгууллага байх болно. Энэхүү эрмүүн зорилгыг биелүүлэхэд чин сэтгэл, хичээл зүтгэлээ зориулан ажилладаг нийт шууданчиддаа, биднийг сонгон үйлчлүүлдэг эрхэм үйлчлүүлэгч нартаа, итгэл хүлээлгэн хамтран ажилладаг түншүүддээ энэ дашрамд халуун талархал илэрхийлье.

Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, ажил үйлс нь өөдрөг байж, өсөн тэлж, өргөжин хөгжихийн елзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Эрхэм та манай компанийн 2019 оны жилийн тайланг минь хүлээн авна уу.

Хүндэтгэсэн:

Гүйцэтгэх захирал
Б.АНХБААТАР

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд



Д.НАРАНГЭРЭЛ

ТУЗ-ийн дарга
ТӨБЗГ-ын ахлах
мэргэжилтэн



Д.ДЭЛГЭРМАА

ТУЗ-ийн гишүүн
ТӨБЗГ-ын
мэргэжилтэн



С.МӨНГӨНЦЭЦЭГ

ТУЗ-ийн гишүүн
СЯ-ны ТЗУГ-ын
СЗБХ-ийн дарга



Ч.ДОНДОГМАА

ТУЗ-ийн гишүүн
ЗГХЭГ-ын ахлах
референт



Ч.ГАНХУЯГ

ТУЗ-ийн гишүүн
Ард Санхүүгийн
Нэгдэл ХК-ийн
гүйцэтгэх захирал



О.ОДБАЯР

ТУЗ-ийн гишүүн
“Эрдэнэс монгол”
ХХК-ийн дэд
захирал



Б.АМАРСАНАА

ТУЗ-ийн хараат
бус гишүүн
“МПЭ” ХХК-ийн
гүйцэтгэх захирал



М.ХАЛИУНБАТ

ТУЗ-ийн хараат бус
гишүүн
“Монгол Айдия”
групийн
гүйцэтгэх захирал



Д.БАЛДОРЖ

Хараат бус гишүүн
Маркетингийн
Холбооны УЗ-ийн
гишүүн

Компанийн 2019 оны зорилтууд

СТРАТЕГИ

ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ ЛОГИСТИК ҮЙЛЧИЛГЭЭ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

УЛС ХООРОНДЫН ШУУДАН

Үйл ажиллагааг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

ХҮРГЭЛТ

Үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлж, нэр төрлийг нэмэгдүүлэх

ЛОГИСТИК ҮЙЛЧИЛГЭЭ


Үйлчилгээг өргөжүүлж, дэд бүтцийг бий болгох

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

МОНГОЛ ШУУДАНГИЙН ТҮҮХ

1921-2019 он



Шуудан харилцаа нь Хүннү гүрний үеэс, он цагийг илүү наашлуулбал их эзэн Чингис хааны хүү Өгөөдэй хааны дөрвөн сайн үйлийн нэг болох сайтар зохион байгуулсан өртөөт зам **"Монголын Морин Өртөө"**-нөөс үүсэлтэй.

Монголын морин өртөө шуудан нь үүсэл хөгжлөөрөө дэлхийн шуудан холбооны түүхэнд анхдагч тэргүүн зэргийн харилцаа холбооны нэгэн төрөлд тооцогддог билээ.

Монгол улс дэлхийн асар өргөн уудам нутгийг эзлэн оршиж байсан үед 1228-1241 онд монголын эзэнт гүрний хаан ширээнд сууж байсан **Чингис хааны гуравдугаар хөвгүүн Өгөөдэй** мэдээлэгч, захирагч нарын бий болгож морин өртөө байгуулсан нь шуудан харилцааны хувьд уургын улааг халж, мэдээлэл харилцаа дамжуулах сүлжээг үүсгэн байгуулсан томоохон дэвшил билээ.

Өртөө нь улам боловсронгуй болон хөгжсөөр Ардын хувьсгал мандсан 1921 оны 7 дугаар сарын 19-нд Ардын засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулсан нь одоогийн 98 жилийн түүхт **Монгол Шуудан** юм.



▪ **1921-07-19**

Ардын Засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор
Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулав.

▪ **1935**

Нийслэлийн Шуудангийн хороо

▪ **1935-1936**

Нийслэлийн Төв Холбооны Төв шуудан тасаг

▪ **1936-1958**

Холбооны Ерөнхий Хорооны харьяа Төв Шуудан

▪ **1958-1960**

Цахилгаан Шуудангийн хороо

▪ **1966-1978**

Төв Шуудан

▪ **1978-1990**

Цахилгаан Шуудан Холбооны газар

▪ **1990-1994**

Шуудан Холбооны газар

▪ **1994**

Монгол Шуудан ТӨУҮГ

▪ **2002**

Монгол Шуудан ХХК

▪ **2009**

Монгол Шуудан ТӨХК

▪ **2016**

Монгол Шуудан ХК



МОНГОЛ ШУУДАН КОМПАНИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



1.

ЛОГИСТИК, ТЭЭВЭР ЗУУЧ

| 2019. 01 дүгээр сар

Логистик, тээвэр зууч Дотоод логистикийн үйлчилгээг өргөжүүлэн, Улаанбаатар хотод логистикийн үйлчилгээг дэмжсэн ачаа бараа буулгах, хадгалах, хүлээн авах орчныг бүрдүүлсэн төвийг байгууллаа.



2.

ЯЛГАН БОЛОВСРУУЛАХ ТӨВ

| 2019. 01. 25

2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Дотоод шуудангийн ялган боловсруулах төвийг шинээр байгууллаа.



3.

БАНКУУДЫН КАРТ ХҮРГЭЛТ

| 2019. 01 дүгээр сар

ХААН БАНК,
ХАС БАНК,
ТӨРИЙН БАНК,
КАПИТАЛ,
ГОЛОМТ БАНК-уудтай

хамтран харилцагчийн картыг хаягаар хүргэх үйлчилгээг эхлүүлэн амжилттай хэрэгжүүлж байна.




7.

ХУР СИСТЕМ

| 2019. 01 дүгээр сар

Монгол улсын засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” -ээр зарласантай холбогдуулан Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК, Монгол шуудан ХК, Үндэсний дата төвтэй хамтран төрийн цахим үйлчилгээний нэгдсэн төвийг Монгол улсын бүх суманд 2019-2020 онд байгуулахаар болж эхний ээлжийн засварын ажлууд хийгдээд байна.



8.

МӨНГӨНИЙ ДУГТУЙ

| 2019. 01 дүгээр сар

Мөнгөний дугтуйны загварыг шинэчлэн 20 гаруй төрлийн сонголттойгоор 380.000 орчим ширхэгийг худалдаанд гарган борлууллаа.



2019



4.

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

| 2019. 01 дүгээр сар

Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний томоохон системүүдийн нэг болох **Еврожайро системд** нэгдэн орсноор Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дэлхийн **60 гаруй** улс оронтой солилцох боломжтой боллоо.



5.

ПАРК ШИНЭЧЛЭЛ

| 2019. 01 дүгээр сар

Үйлчлүүлэгчид, хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэх зорилгоор компанийн 2019 оны хөрөнгө оруулалтаар хот доторх гараас гарт хүргэлтийн үйлчилгээнд зориулж **10ш Пробокс**, Аймаг орон нутгийн парк шинэчлэлд **5ш пургон** машиныг хүлээлгэн өгч техникийн хүчин чадлаа нэмэгдүүлээ.



6.

ДЭЛХИЙН ШУУДАНГИЙН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТЭЭР ЧАНАР САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭВ

| 2019. 01 дүгээр сар

Улс хоорондын шуудангийн илгээмжийн бүртгэлийн IPS 2014 программыг **IPS 2017**-д шилжүүлэх төслийг Дэлхийн Шуудангийн Холбооны чанарын сангаас санхүүжүүлэн амжилттай хэрэгжүүлж, компанид **204 сая** төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийлээ.



9.

ШИЛДЭГ КАЙЗЕН САНАЛ

/Кайзен төсөл/

| 2019. 01 дүгээр сар

Кайзен саналын систем 2018 оны 10-р сарын 26-нд компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээс хойш 2019 онд нийт 107 санал хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулаад байна. Кайзен системийн хэрэгжилтийг хангах үүднээс 2019 онд “Номын өргөө”, “Өнгөт мэдэгдэл”, “Шууданчийн хаягжилтын дэвтэр”, “Нэмэлт эко уут” төслүүдийг амжилттай хэрэгжүүллээ.



10.

ЧАНАРЫН ДУГУЙЛАНГУУД

| 2019. 01 дүгээр сар

Залуусын манлайлал, бүтээлч сэтгэлгээ, багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх зорилгоор “Чанарын дугуйлан”-гийн үйл ажиллагааг анх удаа нэвтрүүлсэн. Шууданчдын хийж бүтээх хүсэл тэмүүлээр байгуулагдсан “Алхам алхмаар”, “Эв Эе” чанарын дугуйлангууд сайжруулалтын төслүүдээ амжилттай хэрэгжүүлсээр байна.





11.

ШИНЭ МАРК

| 2019.01 дүгээр сар

2019 онд сэдвийн төлөвлөгөөний дагуу 19 сэдвийн марк шинээр шуудангийн гүйлгээнд гаргаж, сурталчлах, түгээх, борлуулах мөн нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.



12.

ДЭЛХИЙН 198 ОРНООС “МОНГОЛ ШУУДАН” ХК ШАЛГАРЛАА

| 2019.01 дүгээр сар

НҮБ-ийн мэргэжлийн төрөлжсөн байгууллага болох Дэлхийн Шуудангийн Холбооны EMS-ийн кооперативаас гишүүн орнуудын үйлчилгээний чанар, хэрэглэгчийн үйлчилгээг жил бүр үнэлэн дүгнэдэг бөгөөд Монгол Шуудан ХК дэлхийн 198 орноос шалгаран “Шилдэг хэрэглэгчийн үйлчилгээ”-ний шагнал хүртлээ.

13.

РИ-БРЭНДИНГ:

| 2019. 05 дугаар сар

48-р салбар, 63-р салбар.

17



АЖИЛЧДЫН ХУВЦАС ШИНЭЧЛЭЛ

| 2019. 06 дугаар сар

Зуны ээлжийн хувцас болох Шинэ загварын спорт загварын поло подволкийг УБ хотын “шуудан үйлчилгээний салбаруудад хүлээлгэн өглөө.

Гүйцэтгэх захирлын санаачилгаар анх удаа Улаанбаатар хотын шуудан үйлчилгээний салбарын шууданч нарт үндэсний хувцас үйлдвэрлэгч “ХҮРЭМ” брэндийн өвлийн куртикийг хүлээлгэн өглөө.

18



АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН EMS SYMPOSIUM

| 2019. 08 дугаар сар

Дэлхийн Шуудангийн Холбооны / ДШХ/ EMS-ийн кооперативын Ази, Номхон далайн бүсийн шуудангийн байгууллагуудын удирдах ажилтны 2019 оны хуралдаан 8-р сарын 21-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдлаа. Тус хуралдаанд АНУ, ОХУ, Нидерланд, Нигери, Япон, Хятад болон Ази, Номхон далайн бүсийн 15 орны 30 гаруй төлөөлөгчид оролцлоо.

2019



14.

СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

| 2019. 05 дугаар сар

Монгол шуудан ХК-н шигшээ баг тамирчид ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН СПОРТЫН НААДАМД амжилттай оролцож эрэгтэй волейболын төрлөөр хүрэл медаль хүртлээ.



15

МАРГААШИЙН УДИРДАГЧ

| 2019. 06 дугаар сар

Шуудангийн үйлчилгээний чанар, баг хамт олны үйл ажиллагааг үр дүнтэйгээр зохион байгуулах зорилгоор дунд шатны менежерүүдийг чадавхжуулах "Маргаашийн удирдагч 2019" тусгай хөтөлбөрийг анх удаа хэрэгжүүллээ.



16

МЭРГЭЖИЛТЭНҮҮДИЙН АЖИЛЛАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛЛАА

| 2019. 06 дугаар сар



19.

EMS НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ

| 2019. 08 дугаар сар

Харилцагч компаниудад EMS үйлчилгээг сурталчилан таниулах зорилгоор Монголын томоохон компаниудыг урьж Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр улс хоорондын буухиа шуудангийн давуу тал, онцлогуудыг танилцуулж томоохон байгууллагуудтай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.



20

ТРАНЗИТ ШУУДАН

| 2019. 09 дүгээр сар

"Монгол шуудан" ХК нь ОХУ-ын шуудангийн байгууллага /Почта России/-тай хамтран бүс нутгийн шуудангийн дамжин өнгөрөх үйл ажиллагааг хөгжүүлж ирсэн. 2019.09.03-ны өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путиний Монгол улсад хийж буй албан ёсны дээд хэмжээний айлчлалыг тохиолдуулан хамтын ажиллагаагаа шат ахиулан, "Монгол шуудан" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар, "Оросын шуудан" Ерөнхий захирал Николай Подгузов нар "Эрдэс баялагийн бус экспорт, импортыг дэмжих шуудангийн логистикийг хөгжүүлэх Стратегийн Хамтын Ажиллагааны Гэрээ"-нд гарын үсэг зурлаа.



21

ПРОЦЕССИЙН ЗУРАГЛАЛ

| 2019. 09 дүгээр сар


"Чанартай үйлчилгээ" төслийн багаас Компанийн үндсэн болон дэмжих процессуудыг нийт газар, хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүдтэй хамтран анх удаа зураглах ажлыг зохион байгуулж, процессын хандлага, сэтгэлгээг нийт ажилтнуудын дунд хөгжүүлж, манлайлан ажиллалаа.

НЭГ.

ХҮНИЙ НӨӨЦ, ГАДААД ХАРИЛЦААНЫ АЖЛЫН ХҮРЭЭНД

1.1

Хүний нөөц, хөдөлмөрийн харилцааны талаар





1.2

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар




2019.05 дугаар сард Монгол шуудан компанийн гүйцэтгэх захирал Б.Анхбаатар, дэд захирал Г.Тэлмэн, Ш.Наранбат болон ЗХНГ-ын захирал Д.Төмөрбаатар нар Бүгд найрамдах Турк улсын шуудангийн газарт зочилж албан уулзалт хийлээ. Уг уулзалтын хүрээнд хоёр тал "Хамтран ажиллах санамж бичиг" байгуулж, Анкара хотын шуудан үйлчилгээний газраас туршлага судлан, цахим худалдааны чиглэлээр судалгаа явуулах талаар харилцан санал солилцлоо.



2019.07 дугаар сард Монгол улс, Бүгд найрамдах Турк улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой сэдэвт шуудангийн маркийн анхны өдрийн нээлтийн арга хэмжээнд УИХ-ын гишүүн, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, УИХ дахь Монгол-Туркийн парламентийн бүлгийн дарга Т.Аюурсайхан, БНТУ-ын Үндэсний Их Хурлын дарга Мустафа Шентоп болон Элчин сайд Ахмет Язал болон зочид төлөөлөгчид оролцлоо.



Дэлхийн Шуудангийн Холбооны /ДШХ/ EMS-ийн кооперативын Ази, Номхон далайн бүсийн шуудангийн байгууллагуудын удирдах ажилтаны 2019 оны хуралдаан 8-р сарын 21-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж дэлхийн 15 орны 30 гаруй төлөөлөгчид оролцлоо.



Монгол Шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирал Б. Анхбаатар, ОХУ-ын Шуудангийн байгууллагын Ерөнхий захирал Николай Подгузов нар **"Эрдэс баялагийн бус экспорт, импортыг дэмжих шуудангийн логистикийг хөгжүүлэх стратегийн хамтын ажиллагааны гэрээ"**-нд гарын үсэг зурлаа.





МОНГОЛ
ШУУДАН

Монгол Шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирал Б. Анхбаатар, ОХУ-ын Шуудангийн байгууллагын Ерөнхий захирал Николай Подгузов нар **"Эрдэс баялагийн бус экспорт, импортыг дэмжих шуудангийн логистикийг хөгжүүлэх стратегийн хамтын ажиллагааны гэрээ"**-нд гарын үсэг зурлаа.





ХОЁР.

ШУУДАНГИЙН ТЕХНОЛОГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

2.1

Улс хоорондын шуудангийн сүлжээний ашиглалтыг тасралтгүй, найдвартай хэвийн үйл ажиллагааг хангах талаар



ХҮРГЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ

■ Улс хоорондын орох шуудангийн мэдээллийг гараар шивж гаалийн системд мэдээлдэг болсноор цаг хугацаа алдан (хагас-бүтэн өдрөөр) олон улсад зарласан стандарт хугацаандаа хүргэлт хийгдэхгүй байсныг 9 сарын 7-ноос эхлэн шуудангийн салбаруудад ДШЯБТ-өөр дамжуулахгүйгээр шууд хүргэлтийг өдөртөө зохион байгуулан ажиллаж байна.



ТЭЭВРИЙН МАРШРУТЫГ ОНОВЧЛОХ

■ Улс хоорондын гарах бичиг захидлын транзит улсуудын дамжуулан илгээх үнэ тарифын харьцуулсан судалгаа хийсний үндсэн дээр бичиг захидал, илгээлтийн гарах маршрутыг шинэчилсэн.



ХҮРГЭЛТИЙН СААТЛЫГ БУУРУУЛАХ

■ Гарах шууданг хурдан шуурхай, сааталгүй хүргэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхааран гарах шуудангийн хяналтыг ХҮЛТ-тэй хамтран зохион байгуулж, саатал зөрчил гарсан тохиолдолд тээврийн байгууллага болон хүлээн авагч улс орнуудтай холбогдон даруй шийдвэрлэн, хэрэглэгчид эргэн мэдэгдэж ажилласан.



ИЛГЭЭМЖИЙН БҮРТГЭЛИЙГ САЙЖРУУЛАХ

■ Илгээмжийн бүртгэл мэдээлэл солилцох **EMSEVT 3.0** хувилбарыг бүрэн дүүрэн ашиглах, хэрэгжүүлэх үүднээс солилцох шаардлагатай шат шатны мэдээллийг ялган боловсруулах, хүргэж гардуулах салбар, нэгж бүрт хэрхэн хийх талаар заавар зөвлөмж, хичээл бэлтгэн явуулж, заавар зөвлөмж байнга өгч ажилласнаар дээрх хувилбараар илгээмжийн мэдээллээ солилцож байна.



ТЕХНОЛОГИЙН ПРОЦЕССЫГ ШИНЭЧЛЭХ

- Тасаг нэгжийн зохион байгуулалтыг өөрчлөн багийн зохион байгуулалтанд шилжүүллээ. Ингэснээр ялгагч нарын ачааллыг жигдрүүлж, сул зогсолтгүй ажиллаж байна.
- Технологийн процессыг оновчлох, сайжруулах ажлын хүрээнд улс хоорондын орох, гарах шуудангийн процессын зураглалыг хийн **"Үйлчилгээний чанар"** төслийн багт хүлээлгэн өгсөн.
- Улс хоорондын хариу бичиг захидлын купоныг **анх удаа** Монгол улсын төрийн далбаатайгаар, илгээмжийн зураасан кодыг Дэлхийн Шуудангийн Холбоо (ДШХ)-ны дүрэм журманд зааснаар шинэчлэн захиалж, ханган нийлүүлсэн.


2.2

Улс хоорондын шуудангийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэх талаар


БИЧИГ ЗАХИДАЛ, ИЛГЭЭЛТ БУУХИА ШУУДАНГИЙН ХҮРГЭЛТ ГАРДУУЛАЛТЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ

- Буухиа, илгээлт, бичиг захидлын хүргэлтийн стандартын мөрдөлтийг хангах, ШҮГ болон ШҮС-уудыг илгээмжийн мэдээллээ цаг хугацаанд нь оруулж хэвшүүлэх, алдаа зөрчилгүй ажиллахын тулд УХШЯБТ-өөс орж ирж буй шуудангийн мэдээллийг урдчилан авч хянан, салбар, аймгуудад мэдэгдэн ажиллаж байна.


Бичиг захидлын үйлчилгээний чанар



Илгээлтийн чанар



Буухиа шуудангийн чанар



Мөн үйлчилгээний чанарыг сайжруулах, хяналт тавих нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор 2019 оны 9 дүгээр сараас ДШХ-оос хэрэгжүүлж буй “Data compliance” төсөлд нэгдэн нийт 10 төрлийн тайлан авч, тайлангаар ирүүлсэн алдаа дутагдлыг засаж сайжруулан чанарын үзүүлэлтийг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна.

ГААЛЬ, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ, ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

■ 2019 оны 5 дугаар сарын 1-нээс орох шуудангийн илгээмжийн мэдээллийг илгээмж нэг бүрчлэн гар аргаар бүртгэж, UPOST системээр дамжуулан гаалийн байгууллагад өгч байгаа бөгөөд үүнээс шалтгаалан орох илгээмжийг хүлээн авах, гаалийн хяналтанд оруулах, ялган боловсруулах, салбар аймагт бэлдэж гаргах зэрэг технологийн бүх ажиллагаа сааталтай явагдаж байна. Энэ ажил нь илгээгч улсуудтай гаалийн урьдчилсан мэдээлэл- ИМАТТ солилцох хүртэл үргэлжилнэ.

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЛАВЛАХ ТӨВ 1800-1613



■ харилцах
утсаар **67483**
дуудлага хүлээн
авч,



■ үйлчилгээний
заалаар **4594**
хүнд үйлчлэн,



■ байгууллагын
сайтын чатаар
2788



■ дотоод
сүлжээгээр
915




■ компанийн
фэйсбүүк
хуудсаар **1920**

асуулгад тус тус хариулт өгсөн.

Хэрэглэгчээс байгууллагын үйлчилгээний чанартай холбоотой гомдол-**15**, хүргэлт болон гардуулалтын хурдтай холбоотой гомдол-**8**, үйлчилгээний ажилтны зан харилцаатай гомдол-**5**, сайтаар шуудан хянахад хүндрэлтэй-**7** тус тус хүлээн авч холбогдох газруудад нь мэдэгдэн, шийдвэрлүүлэхээр шилжүүлэн өгсөн байна.

■ ХҮЛТ-ийн буухиа шуудангийн хэрэглэгчдэд үзүүлсэн үйлчилгээний чанараар ДШХ-ны EMS-ийн зөвлөлийн 2018 оны "Шилдэг хэрэглэгчийн үйлчилгээ"-ээр шалгарсан ба 2019 онд энэхүү амжилтаа бууруулахгүй байхаар зорилт тавин ажиллалаа.





2.3

Дотоод шуудангийн үйл ажиллагааны талаар

ШУУДАН СОЛИЛЦООНЫ БҮРТГЭЛ, СУДАЛГАА ХИЙХ

- Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний байнгын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааны хүрээнд орох, гарах чиглэлд шуудан ялган боловсруулж, хүргэлээ.

 180,418ш
богц буюу

 1,643.025 кг

- Үүнээс өөрийн тэвэрээр Даваа, Лхагва, Баасан гаригт **Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Булган** аймгийн орох, гарах чиглэлд шуудан тээвэрлэж хүргэснээр дээрх чиглэлийн шуудангийн илгээмжийн аюулгүй байдал, хяналтын хугацаа, хүргэлтийн чанар дээшилсэн.

 7,354
богцоор

 59,228.2 кг

- Илгээмж тус бүрээр задалбал,



буухиа шуудан
129,015 ширхэг,



бичиг захидал
1,712.413 ширхэг,



илгээлт
17,980 ширхэг,




хэвлэл
4,913.209 ширхэгийг

тус тус ялган боловсруулж, хүргэжээ.

Шуудангийн саатал

- Сааталтай хүргэгдсэн шуудангийн илгээмжийн тоо хэмжээ нь нийт солилцооны **0.033%**-ийг эзэлж байгаа бөгөөд бүх нийтийн үйлчилгээний чанарын саатлын үзүүлэлтийн **зөвшөөрөгдсөн хэмжээнд** байна.

ДОТООД ШУУДАНГИЙН ИЛГЭЭМЖ





ГУРАВ.

ТЭЭВЭР ЗУУЧ, ЛОГИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

3.1

Транзит шуудан - Автомашин, төмөр замаар транзит тээвэр



2019 оны 7 дугаар сарын 1 өдөр Оросын шуудангийн охин компанитай гэрээ байгуулж, БНХАУ-аас ОХУ-руу чиглэсэн шуудан илгээмжийг Монгол улсаар дамжуулан өнгөрүүлэх хамтын ажиллагааг дахин эхлүүлэв.


Транзит шуудангийн үйлчилгээг эхлүүлэх, зохион байгуулахтай холбоотой хийгдсэн гол ажлуудаас тоймлон дурдвал:

- Оросын шуудангийн охин компанитай 2019 оны 7 сарын 1-ээс гэрээ байгуулж, туршилтын тээврийг эхлүүлэв
- Оросын шуудан компанитай 3 төрлийн бүтээгдэхүүн солилцох 2 талт гэрээ байгуулав
- Оросын шуудан компанитай эрдэс баялагийн бус салбарт хамтран ажиллах стратегийн түншлэлийн гэрээ байгуулав.
- БНХАУ-аас Улаанбаатар – Москва чиглэлийн зорчигч тээврийн галт тэргэнд дамжин өнгөрөх шуудан тээвэрлэх үйл ажиллагааг хамтран зохион байгуулав

Автомашинаар

ТЭЭВРИЙН ТОО


2019 онд автомашинаар гүйцэтгэсэн
транзит тээврийн тоо:



Тонн

ШУУДАНГИЙН ХЭМЖЭЭ


2019 онд дамжуулан өнгөрүүлсэн транзит шуудангийн хэмжээ:



Сая ширхэг

ШУУДАНГИЙН ТОО ХЭМЖЭЭ

2019 онд дамжуулан өнгөрүүлсэн транзит шуудангийн тоо ширхэг:



3.2

Хот доторх гараас гарт хүргэлтийн үйлчилгээ

ШИНЭЭР АВСАН ХОТЫН ХҮРГЭЛТИЙН АВТОМАШИН:



2019 оны 8 сарын 1 өдрөөс эхлэн тээврийн үйлчилгээнд гарч эхэлсэн.

Хотын доторх гараас гарт хүргэлтийн үйлчилгээг эхлүүлэх, зохион байгуулахтай холбоотой хийгдсэн гол ажлуудаас тоймлон дурдвал:

- Гараас гарт, салбараас салбарт олголт үйлчилгээг эхлүүлсэн,
- Гараас гарт хүргэлт үйлчилгээний систем, хүргэгчийн апп нэвтрүүлсэн,
- Орон нутгийн дайврын хот доторх хүргэлтийн үйлчилгээг эхлүүлсэн,



ДӨРӨВ.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

4.1

Программ хангамж хөгжүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг хангах

- Шууданчийн гар утасны гардуулалтын аппликешин хамгаалалтыг сайжруулж шууданч бүрт том жижиг үсэг, тоо, тусгай тэмдэгт оролцсон нууц үг оноож өгсөн. 2019 онд ШҮС-уудын **112** шууданчид гар утаснаас **1.027,067** ширхэг гардуулалт хийгдсэн байна.
- 2019/03 сард **50ш** PDA төхөөрөмжид шаардлагатай програм хангамжийг суулган бэлтгэж салбаруудад тараасан. Шуудан гардуулалтын **PDA 3.0 MobileApp** тестийн хувилбарыг амжилттай тестлэсэн.
- Транзит үйлчилгээний шаардлагаар улс хооронд ITMATT мэдээлэл солилцох ажлын хүрээнд FTP сервер шинээр бэлдэж бүх тохиргоонуудыг хийж гүйцэтгэсэн, ITMATT мэдээллийг UPU дамжуулж авах шийдвэр гарсан тул UPU хамтран ажилласан.



Бусад программ хангамжийн хөгжүүлэлтийн хүрээнд:

- Дотоод мессенжерийн **Spark** системийн үйлдлийн системийг **UBUNTU** дээр суулгаж, серверийн хувилбарыг шинэчлэв.
- УБ хотын баруун логистик салбарт тээш, дайвар ачаа бүртгэх программ хангамж хийж ашиглалтанд оруулсан. Энэ нь бүртгэл тооцоог хянаж, гар ажиллагааг хөнгөвчилсөн ба тайлан мэдээг программаас гаргадаг болсон.
- **VeritechERP** системийн хурдыг ихэсгэх зорилгоор мэдээллийн санг үзүүлэлт сайтай сервер компьютерт шилжүүлэн хэвийн горимд оруулав.



МАРК БҮР ТҮҮХ ӨГҮҮЛДЭГ



EVERY STATE

ТАВ.

5.1

Марк үйлдвэрлэл

2019 онд **19 сэдвийн** марк шинээр гаргалаа.



Гахай жил. 1040



Оюун ухааны музей. 1043



Халх гол 80 жил. 1048



Алтан марк. 1041

Эрдэнэт 40н жил



Монгол Марк 95 жил. 1042



Товгор хэвлэлттэй марк. 1046

Монгол Турк 50 жил



Эрвээхэй. 1044



Махатма Гандхи
150 жил. 1051



Монгол Хятад 70 жил. 1052



Made in Mongolia. 1045



EMS 20 жил. 1050



Чэгдаржав
150 жил
1057

2019 ОНЫ ШИНЭ МАРКУУД

Цагаан зандангийн
үнэртэй марк. 1058


Хутагт
хувилгаан II



Саран дээр хүн буусан 50 жил. 1047



Хутагт хувилгаан I. 1049



Улаанбаатар 380 жил. 1053



Үээсгэлэнт газар II. 1054



1055

UNESCO
1056

5.2

Дугтуй, үнэт цаасны үйлдвэрлэл

АНХНЫ ӨДРИЙН ДУГТУЙ



Гахай жил. 1040



Эрдэнэт 40н жил



Монгол Марк 95 жил. 1042



Оюун ухааны музей. 1043



Made in Mongolia. 1045



Made in Mongolia. 1045



Саран дээр хүн буусан 50 жил. 1047



Халх гол 80 жил. 1048



Хутагт хувилгаан I. 1049



EMS 20 жил. 1050



EMS 20 жил. 1050



EMS 20 жил. 1050



Улаанбаатар 380 жил. 1053



Үзэсгэлэнт газар II. 1054



UNESCO 1056

Чэгдаржав
150 жил
1057



Хутагт
хувилгаан II

МӨНГӨНИЙ ДУГТУЙ



Хуурч өвгөн



Морин хуурь



Хадаг барьсан охин



12 жил



Мөнгөн аяга, хос домбо



Бурханы найман тахил



Морин эрдэнэ



Тэмээтэй хүүхэд



Зоосон мөнгө, алт



Манан хөөрөг, даалин



Цагаан өвгөн



Хубилай хаан



Зоосон хээ



Хурдан морь



Цаа унасан хүүхэд



Баярын мэнд хүргэе



Эвтэй дөрвөн амьтан


ЗУРГАА.

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Ширхэг


СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Нийт солилцоо	1,610,819	1,571,830	1,757,660	2,302,599	2,653,661
Дотоод	1,090,199	1,102,770	1,288,531	1,590,703	2,082,944
Бичиг захидал	1,040,995	1,050,051	1,122,595	1,512,814	2,009,719
Боодол	25,944	28,554	46,054	55,928	51,766
Илгээлт	23,260	24,165	24,882	21,961	21,459
Улс хооронд	520,620	469,060	469,129	711,896	570,717
Улс хооронд Гарах	263,493	230,098	204,502	177,930	191,276
Улс хооронд Орох	257,127	238,962	264,627	533,966	379,441




НИЙТ СОЛИЛЦОО: 2019 онд өмнөх жилээс **15.25** хувиар өссөн ↑

ДОТООД ШУУДАНГИЙН СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТ



Дотоод нийт солилцоо: 2019 онд өмнөх жилээс **30.94** хувиар өссөн ↑

УЛС ХООРОНД ШУУДАНГИЙН СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТ



Гадаад нийт солилцоо: 2019 онд өмнөх жилээс **19.83** хувиар буурсан ↓


ОРЛОГО, ЦЭВЭР АШИГ

2015-2019 он

Сая.төгрөг


Дансны нэр	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Нийт орлого	10,094.19	11,923.10	13,627.63	15,473.96	16,725.01
Татварын дараах цэвэр ашиг	94.01	1,006.58	1,224.16	1,560.27	1,103.56

НИЙТ ОРЛОГО




ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ

2015-2019 он



НИЙТ ХӨРӨНГӨ

2015-2019 он




Тус компанийн нийт активын хэмжээ 2019 оны жилийн эцэст **33,484.5 сая** төгрөгт хүрч урьд оныхоос **1.5** хувиар буурсан байна ↓.

Компанийн эргэлтийн хөрөнгө 2018 онд нийт хөрөнгийн **75.4** хувийг эзэлж байсан бол 2019 оны **73.1** хувь болон буурч ↓ компанийн эрсдэл өндөртэй активын хэмжээ багаслаа.

НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

2015-2019 он



2019 оны жилийн эцэст богино хугацаат өр төлбөр **10,560.9 сая** төгрөгт хүрч, өмнөх жилээс **8.2** хувиар буурсан ↓ бол хуримтлагдсан ашгийн хэмжээ **4,336.4 сая** төгрөгт хүрч, 2018 оноос **10.5** хувиар өсчээ ↑.



САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он	2019 он
Цэвэр ашиг	<i>төгрөг</i>	1,560,267,623.05	1,103,559,718.68
Нийт хувьцааны тоо	<i>ширхэг</i>	99,586,363	99,586,363
Нэгж хувьцааны үнэ	<i>төгрөг</i>	684.03	725.00
Нэгж хувьцааны дансны үнэ	<i>төгрөг</i>	226.06	230.19
Зах зээлийн үнэлгээ	<i>тэрбум төгрөг</i>	68.12	72.20
Нэгж хувьцааны өгөөж /EPS/	<i>төгрөг</i>	15.67	11.08
Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	-	0.0459	0.0333
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/	-	0.0693	0.0481
Нийт хөрөнгийн эргэц /ROTA/	-	0.0512	0.0368


ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ АРИЛЖАА

2019 онд нийт **166 өдрийн** арилжаанд идэвхитэй байж,

2019.01.02 - **680.00** төгрөгийн нээлтийн ханштайгаар эхэлж, 2019.02.31 - **725.00** төгрөгт хүрч тайлант оны арилжааг хаалаа

Компанийн Хөрөнгийн бирж дээрх үнэлгээ **68.12 тэрбум** төгрөгөөс оны эцсийн байдлаар **5.99↑** хувиар өсч **72.20 тэрбум** төгрөгт хүрээд байна. Өнгөрсөн 2019 онд компанийн хувьцааны ханшийн хэлбэлзлийг (хаалтын ханш) харвал:


ХУВЬЦААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ



Компанийн зах зээлийн үнэлгээ оны эцсийн байдлаар **72.2 тэрбум** төгрөг

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2019 оны жилийн эцсийн байдлаар компанийн нийт хувьцааны **66** хувийг Төрийн өмч, **25.56** хувийг Ард Санхүүгийн Нэгдэл, **8.44** хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна





МОНГОЛ
ШУУДАН

ГАДААД ХЭВЛЭЛ ЭХНИЙ ХАГАС ЖИЛГ

Automobile
Design

BMW'S DAZZLING
NEW SERIES
of the Year
IT WEARS AND
LIVES THE LIFE

NATIONAL
GEOGRAPHIC

KIDS



SAVE
EARTH

NATIONAL
GEOGRAPHIC

ГАДААД ХЭВЛЭЛ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛГ

САНДЫН
ЖУРНАЛ





МОНГОЛ
ШУУДАН

Өдөр бүр уулзах үндэсний
шилдэг компани



Фото зургийг Төгөл
Төв аймаг



АУДИТЫН ТАЙЛАН



АУДИТЫН ТАЙЛАН

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18-р зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гарсан.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	17,267,083,063.60	16,648,915,943.48
Дансны авлага	5,788,142,997.08	4,345,338,954.87
Татвар, НДШ – ийн авлага	11,214,579.94	7,148,982.18
Бусад авлага	368,786,936.46	888,913,568.81
Бараа материал	2,095,115,996.76	2,383,652,392.52
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	106,902,720.24	189,433,604.75
Эргэлтийн хөрөнгийн дүн	25,637,246,294.08	24,463,403,446.61
Үндсэн хөрөнгө	8,068,309,950.53	8,725,816,424.32
Биет бус хөрөнгө	304,812,810.22	294,796,411.16
Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,373,622,760.75	9,021,112,835.48
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	34,010,869,054.83	33,484,516,282.09
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Дансны өглөг	10,213,019,917.75	9,560,914,328.30
Цалингийн өглөг	0.29	0.29
Татварын өр	69,130,787.96	143,669,465.47
Урьдчилж орсон орлого	989,525,152.12	569,653,929.72

Бусад богино хугацаат өр төлбөр	226,701,941.52	286,684,498.64
Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,498,377,799.64	10,560,922,222.42
Нийт өр төлбөрийн дүн	11,498,377,799.64	10,560,922,222.42
Өмч: - төрийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
- хувийн	3,385,936,300.00	3,385,936,300.00
Нэмж төлөгдсөн капитал	2,538,512,210.45	2,538,512,210.45
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
Эздийн өмчийн бусад хэсэг	2,710,106,959.73	2,710,106,959.73
Хуримтлагдсан ашиг	3,925,316,261.18	4,336,419,065.63
Эздийн өмчийн дүн	22,512,491,255.21	22,923,594,059.66
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	34,010,869,054.85	33,484,516,282.08

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Борлуулалтын орлого (Цэвэр)	14,386,649,985.51	15,465,766,821.01
Борлуулалтын өртөг	13,144,919,741.79	14,465,061,535.25
Нийт ашиг (алдагдал)	1,241,730,243.72	1,000,705,285.76
Түрээсийн орлого	107,973,100.29	127,345,944.06
Хүүний орлого	978,515,051.27	747,571,028.84
Бусад орлого	822,000.00	0
Ерөнхий ба удирдлагын зардал	885,838,643.78	838,289,158.16
Бусад зардал	193,018,362.95	203,221,959.84
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	490,648,872.41	378,236,702.28
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	1,588,718.55	6,090,000.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,742,420,979.51	1,218,437,842.94
Орлогын татварын зардал	182,153,356.46	114,878,124.26
Татварын дараах ашиг (алдагдал)	1,560,267,623.05	1,103,559,718.68
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,560,267,623.05	1,103,559,718.68
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	1,560,267,623.05	1,103,559,718.68

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	73,491,611,313.80	50,675,111,233.10
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	10,722,574,208.53	12,999,975,738.63
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	26,889,263.00	27,541,779.00
Татаас, санхүүжилтийн орлого	2,949,578,177.70	3,076,746,737.76
ҮҮА-ны бусад мөнгөн орлого	59,792,569,664.57	34,570,846,977.71
Мөнгөн зарлагын дүн (-)	84,212,951,149.00	50,402,573,835.85
Ажиллагчдад төлсөн	5,831,386,746.04	6,300,045,005.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,565,126,881.78	1,790,605,298.39
Бараа материал худалдан авахад төлсөн	1,840,637,770.90	2,034,093,179.39
Ашиглалтын зардалд төлсөн	1,521,112,339.01	1,284,790,198.09
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,057,024,179.61	2,793,325,608.03
Татварын байгууллагад төлсөн	1,074,823,569.66	1,115,206,307.45
Даатгалын төлбөрт төлсөн	47,385,763.25	37,935,662.00
ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	70,275,453,898.75	35,046,572,577.50
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(10,721,339,835.20)	272,537,397.25
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	1,544,805,269.79	607,002,945.57
Хүлээн авсан хүүний орлого	1,194,805,269.79	607,002,945.57
Хөрөнгө оруулалтын бусад мөнгөн орлого	350,000,000.00	-
Мөнгөн зарлагын дүн (-)	531,676,476.00	1,529,755,538.61
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	523,176,476.00	1,501,305,538.61
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,500,000.00	28,450,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	1,013,128,793.79	(922,752,593.04)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	-	-

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Мөнгөн зарлагын дүн (-)	442,596,781.13	577,675,719.04
Төлсөн ногдол ашиг	354,457,491.53	451,294,040.74
СҮА-ны бусад мөнгөн зарлага	88,139,289.60	126,381,678.30
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(442,596,781.13)	(577,675,719.04)
Валютын ханшийн зөрүү	758,574,566.17	609,723,794.71
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(9,392,233,256.37)	(618,167,120.12)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,659,430,971.97	17,267,083,063.60
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,267,083,063.60	16,648,915,943.48

Төгрөг

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	2,710,106,959.73	2,829,891,394.68	21,417,066,388.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	2,710,106,959.73	2,829,891,394.68	21,417,066,388.71
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	1,560,267,623.05	1,560,267,623.33
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	(97,932,544.00)	(97,932,544.00)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(366,910,212.81)	(366,910,212.81)
2018 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	2,710,106,959.73	3,925,316,261.18	22,512,491,255.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(224,384,918.80)	(224,384,918.80)
Залруулсан үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	2,710,106,959.73	3,700,931,342.38	22,288,106,336.41
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	1,103,559,718.68	1,103,559,718.68
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	468,071,995.46	468,071,995.46
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	2,710,106,959.73	4,336,419,065.63	22,923,594,059.66




“МОНГОЛ ШУУДАН” ХК

Сүхбаатарын талбай-9, ЧД, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, Ш/Х-1106,
Улаанбаатар-15160, Монгол улс

+(976) 1800-1613

info@mongolpost.mn

 [TheMongolPost](#)

 [Монгол шуудан /Mongol shuudan/](#)

 www.mongolpost.mn

